

## ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХАРИЛЦААНЫ ЗУРАГЛАЛ

*И.Энхболд\**

***Abstract:** 2020 will mark 30th Anniversary of diplomatic relations between Mongolia and the Republic of Korea. While it may seem the two countries' relationship is more developed compared to that of other countries', on its anniversary it is time to reflect back on the past and re-imagine roadmap to the future. This article explores ways to re-formulate cooperation philosophy, to re-build trust in the context of cultural premises, to meet political promises, and to plan a win-win economic partnership based on re-defined values and re-aligned interests.*

***Key words:** cultural exchange, cooperation, trust, interests, value, cooperation*

\*\*\*

### **Байнгын хамтын ажиллагаа**

Монгол Улсын хувьд Улаанбаатар хот, төвийн 6 дүүргийн хэмжээнд БНСУ-ын муж хотуудтай идэвхтэй харилцаа тогтоон заримтай нь ах дүүгийн холбоо тогтоон байнгын хамтын ажиллагаатай байдаг. Харин энэ харилцаа, хамтын ажиллагааг цаашид сайжруулах, засах зүйлс нэлээдгүй бий. Хоёр улсын хамтын ажиллагааг ард иргэд, төрийн болон төрийн бус байгууллага гэсэн үндсэн гурван түвшинд хөгжүүлснээр иж бүрэн хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Өнөөдөр буцалтгүй тусламж үзүүлдэг Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг /KOICA/, хөнгөлөлттэй зээл хариуцдаг Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/, БНСУ-ын худалдаа, хөрөнгө оруулалтыг сурталчилах агентлаг /KOTRA/ зэрэг байнгын хамтын ажиллагаатай гурван том байгууллага, Намянжү соёлын төв, Солонгос хэлний Сэжүн институт, Солонгос иргэдийн нийгэмлэг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Харин хоёр улсын хамтарсан аль нэг салбарын төрийн, төрийн бус байгууллага одоо хүртэл бий болсонгүй. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Япон төвийн хувьд 2016 онд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээний дагуу экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах боломжтой 500 гаруй аж ахуй нэгжид бизнесийн сургалт явуулах, улмаар Японд дадлагажуулах, бүтээгдэхүүнийг нь худалдан авах гэх мэт олон ажлыг амжилттай хэрэгжүүлсээр байна.

Харин ЗХА-д хамтын ажиллагаа хөгжүүлэх ажил өрнөж байгаагийн нэг илрэл бол БНСУ-ын Гёнги муж ба БНХАУ-ын Гирын мужийн хооронд ах дүү мужийн

---

\* ШУА-ийн ОУХХ ЭША доктор(Ph.D)

гэрээг 2019 оны 10 дугаар сард байгуулсан бөгөөд “ЗХА-ын энх тайван эдийн засгийн хамтын нийгэмлэг” хэрэгжилтийг хангах харилцан ашигтай түншлэлийн харилцаа үүсгэв. Гирин муж нь Хятадын зүүн хойд гурван мужаасаа эдийн засгийн хөгжлөөр хамгийн эхэнд байдаг бөгөөд Хятадын хамгийн том хүнсний үйлдвэрлэл, автомашины үйлдвэрлэл, хурдны галт тэрэгний үйлдвэрлэл, аялал жуулчлал зэрэг олон салбараар улсдаа тэргүүлдэг юм. Энэхүү муж нь Умард Солонгостой 1206 км хилийн зурвастай, хамгийн их солонгос үндэстэн амьдардаг, Солонгосын нэгдэлд чухалд тооцогдох бүс хэмээн тооцдог. Цаашид харилцан тэгш байх зарчмын дагуу эдийн засаг, худалдаа /ялангуяа автомашины сэлбэгийн худалдаа/, ХАА, ШУТ, байгаль орчин, соёл боловсрол, спорт, нийгмийн халамж, хүмүүнлэгийн гэх мэт олон салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тусгажээ. Энэхүү уулзалтаар Солонгосын хойг ба Хятад, Япон, Монгол, Орос зэрэг улсуудыг багтаасан ЗХА-ийн энх тайван, эдийн засгийн хамтын нийгэмлэг” байгуулах санаачилгыг урагшлуулах нэг алхам болохыг тэмдэглэсэн байна. 2019 оны 11 дүгээр сарын 5,6-ны өдрүүдэд БНСУ-ын Сэжүн хүрээлэн, Жэжү энх тайвны хүрээлэн хамтран “2019 оны ЗХА-ийн энхтайван хамтын ажиллагааны форум” зохион байгуулав.<sup>2</sup> Энэхүү форумд Өмнөд Солонгос, Хятад, Япон, Орос, Монгол, Австрали, Шинэ Зелланд, ЕХ, АСЕАН, Европын холбооны аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон газраас албаны болон бусад зочид оролцжээ. Гол зорилго нь ЗХА-ийн энх тайван, хөгжил, Солонгосын хойгийн ЗХА-тай холбоход оршиж байв. Энэ хүрээнд ЗХА-ийн төмөр замын хамтын нийгэмлэг, хил дамнасан агаарын бохирдол, гамшгаас урьдчилан сэргийлэх, спорт, соёл, аялал жуулчлалын салбарт хамтрах зэрэг сэдвийн хүрээнд санал солилцжээ.

Хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, урт хугацаанд үр дүн авч ирэх үндсэн философи нь амлалтаа биелүүлэх явдал юм. Дипломат харилцаа байгуулснаас хойших харилцааны хамтарсан мэдэгдэл, амлалт, гэрээ, санамж бичиг зэргийг уншиж үзэхэд амлалтаа биелүүлээгүй, хойшлуулсан, хүчингүй болгосон зүйлс нэлээдгүй тааралдана. Амлалтаа биелүүлэхэд эрсдэлийг хуваалцах, харилцан ашигтай байх, тогтмол уулзалт хийх, хурал зөвлөгөөнийг тогтмолжуулах, асуудлыг тодорхойлох зэрэг олон хүчин зүйлс нөлөөлнө. Эдгээрийг хэмжих, үнэлэлт дүгнэлт өгөх, хүрээ хязгаарыг тогтоох, тодорхой хугацаанд төлөвлөгөө гаргах зэргээр хоёр улсын хамтын ажиллагааны нэгдсэн философитой болох нь зүйтэй төдийгүй цаашид гүнзгий судлах шаардлага урган гарч байна. Энэхүү философи нь хоёр улсын харилцааг модтой зүйрлэвэл тогтмол шаардагдах устай дүйцэхүйц чухал хэсэг юм.

### Соёлын харилцаа

Өнөөг хүртэл ЗХА-д аюулгүй байдал, цөмийн зэвсэг, цэрэг арми, эдийн засаг, худалдааны хориг, улс төрийн харилцан маргаан нь явуургүй болох нь улам

<sup>2</sup> <https://www.hankyung.com/politics/article/201911043475Y>

бүр нотлогдсоор ирлээ. ЗХА-д улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг урт хугацааны турш хадгалах хүчин зүйл шаардлагатай байна. Аливаа хоёр улсын гүн бат найрамдалт харилцааны суурь нь соёл байдаг. Соёлын харилцаа нь ард түмэн хоорондын итгэлцэл дээр тогтдог тул аливаа улс төрийн маргаан, шашны мөргөлдөөн, цөмийн зэвсэг, худалдааны дайн зэргийг зөөллөж өгдөг төдийгүй бусад салбарын харилцааг бодвол удаан үргэлжилдэг. Нэгэнт соёлын харилцаа тогтсоны дараа жижиг маргаан, үл ойлголцлыг ард түмэн хоорондын итгэлцлийг эвдэхгүйн тулд дараад өнгөрдөг тохиолдол цөөнгүй бий. Учир нь олон улсын харилцааны хамгийн том үнэт зүйл нь итгэлцэл юм. Итгэлцлийг төрүүлж, бойжуулж, өсгөх нь нялх хүүхэд асрах мэт маш эмзэг нарийн ажиллагаа шаарддаг боловч нэгэнт суурь тавигдсан тохиолдолд улс төр, эдийн засгийн ямар ч хүчин буулган авахад амаргүй юм.

ЗХА-д будда, кунзын шашны нөлөө ихтэй. Ихэвчлэн гэр бүлд тулгуурладаг тул итгэлцэл олон нийтийг хамарч чаддаггүй. Христийн шашны хувьд итгэл нэгт хүмүүсээ ахан дүүс гэж үздэг тул нийтээрээ нэг гэр бүл мэт итгэл төрүүлдэг. Учир нь хүүхдийг багаас нь шашны бүлэг юм уу сүм хийд, дунд юм уу их сургууль, арми юм уу компани гэхчлэн янз бүрийн байгууллагад татан оруулж, гэр орных нь хүрээнээс гаргадаг учир гэр бүлийн гадуурх хүй хамтлаг илт илүү нэр хүндтэй байсаар иржээ.<sup>3</sup> Тиймээс Азийн ард түмэн хоорондоо итгэлцэлтэй болохын тулд хоорондоо ойр дотно соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал хэмээн үзэж болох юм. Ялангуяа шинжлэх ухаан, боловсрол, урлаг, спорт, аялал жуулчлал, хүмүүнлэгийн харилцан туслалцаа зэрэг 6-н үндсэн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх нь ирээдүйд итгэлцэл төрүүлэх хүчин зүйл байж болно. Тухайлбал Пёнчаны өвлийн олимпод хоёр Солонгосын хамтарсан баг тамирчид оролцсоноор дэлхийн улс төрийн амьдралд ихээхэн өөрчлөлт авч ирснийг бид мэднэ.

Зөвхөн эрх ашигт суурилсан олон улсын харилцаа нь тогтворгүй, эмзэг, нуран унах магадлал өндөр бөгөөд элсэн дээр байшин барихтай адил юм. Харин үнэт зүйлд суурилсан харилцаа нь тогтвортой, хатуу, нуран унах магадлал бага бөгөөд хадан дээр байшин барихтай адил юм. Үнэт зүйлсийг хүний эрх, эрх чөлөө, шударга байдал гэхээсээ илүү хоёр улсын харилцааны итгэлцэл хэмээн ойлгож болно. Тухайлбал, АНУ, Умард Солонгосын аль аль нь шударга байдал, аюулгүй байдал, хүний эрх, улс төрийн эрх чөлөөг байгуулах тухай ярьдаг боловч хоорондоо итгэлцэл байхгүй тул ойлголцож чаддаггүй. Хэрэв Умард Солонгос цөмийн зэвсгээс татгалзвал улс оронд нь хохирол учрахгүй гэх баталгааг АНУ гаргаж чадахгүй байгаа төдийгүй уг баталгааг гаргалаа ч Умард Солонгост итгэл төрүүлэхэд хэцүү.

Өөрөөр хэлбэл олон улсын харилцааны суурь нь соёлын салбарын харилцаа, соёлын салбарын харилцааны үндэс нь хоёр улсын хоорондын итгэлцэл юм. Солонгос үндэстний хувьд манай улстай түүхэн найрсаг харилцаатай ард түмэн юм. Монгол хөх толботой, төстэй царайтай, хэлний бүтэц төстэй, урал алтай

<sup>3</sup> Фрэнсис Фукуяма, “Итгэлцэл-2”, НЕРКО, 369 дүгээр тал.

язгууртай нэг үндэстэн хэмээх үгийг Солонгос хүн бүрээс сонсож болно. Дундад зуунд Солонгосын гүнж нарыг олноор нь ургийн харилцаанд оруулахаар Монгол руу илгээдэг байсан тул Монголын ээж улс хэмээн өөрсдийгөө нэрлэх нь ч бий. 1990 онд албан ёсны харилцаа тогтоосны дараа харилцаа улам бүр өргөжин өнөөдөр 200 гаруй сая ам.долларын худалдаа хийгдэж, 50 гаруй мянган монголчууд сурч, ажиллаж байна. Энэ хугацаанд албан бус тооцоогоор 100.000 гаруй мянган ард Солонгос улсад ажиллаж үзсэн, хэлийг нь ямар нэг хэмжээгээр мэдэж байна. Мөн 3000 гаруй монгол эмэгтэй солонгос хүнтэй гэр бүл батлуулсан бөгөөд солонгос улсад өсөж хүмүүжсэн монгол хүүхдүүд, эрлийз хүүхдийн тоо олширсоор, гэх мэтчилэн Монголд олон салбарт харилцаа, хамтын ажиллагаатай улсыг зөвхөн БНСУ гэхэд хэн ч маргахгүй билээ.

Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг БНСУ-ын гадаад хэргийн тэргүүн дэд сайд Жу Сэ Ён-той уулзахдаа соёл, боловсролын салбар дахь солилцооны ач холбогдлыг тэмдэглэж, соёлын өвийг сэргээн засварлах чиглэлд боловсон хүчин бэлтгэх, Монгол судлалыг хөгжүүлэх, Монголын соёлын өвийг хамгаалах ажил, арга хэмжээнд дэмжлэг үзүүлж байхыг Солонгосын талд хүсэлт болгосон<sup>4</sup> нь соёлын харилцааг хөгжүүлэх эрмэлзэлтэй байгааг илтгэж байна. Хоёр улсын харилцааг модтой зүйрлэвэл соёлын харилцаа нь модыг тэтгэгч үндэстэй дүйцэж болох юм.

### Улс төрийн харилцаа

2020 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хоёр улсын дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн болно. Ойн хүрээнд улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн 30-н том арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөжээ. Энэхүү ойг угтан иж бүрэн түншлэлийн харилцаанаас Стратегийн түншлэлийн харилцаанд шилжих бэлтгэл ажил явагдаж эхэлсэн байна. Өнөөдрийн түвшинд хүрэхэд манай хоёр орны хоорондох харилцааны алдаа оноог нягтлан үзэхээр тэртээ 30 жилийн өмнөх улс төр эдийн засгийн хамтын ажиллагааг бага боловч дурдах нь зүйтэй болов уу.

БНМАУ-тай албан ёсны дипломат харилцаа тогтоохоос өмнө БНСУ-ын умардын бодлогын хэрэгжилтийн хүрээнд Европын зах зээлд гарах, гадаад харилцаагаа баруун хойд зүгт өргөжүүлэх, шинэ зах зээлийг нээх зэрэг олон хэрэгцээ шаардлагатай тулгарсан. Энэхүү асуудлыг хүрээнд манай талд тавьж байсан саналууд байдаг.<sup>5</sup> Тухайлбал, 1988 оны 9 дүгээр сарын сүүлээр “Ханжин” групп худалдаа хийх, иргэний агаарын тээвэрт хамтрах, 1989 оны 3 дугаар сард МИАТ, Кореан Айр компаниуд Бээжинд уулзалт зохион байгуулж Сөүл, Бээжин, Улаанбаатар, Москва чиглэлийн агаарын зам нээж, холбогдох, 1989 оны 9 сард Дэү группийн төлөөлөгчид ирж бугын цусан эвэр, халуун угаалгын ноос авах зэрэг хүсэлтүүдээ илэрхийлсэн байдаг.

<sup>4</sup> <http://www.mfa.gov.mn/?p=51824>

<sup>5</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-01, Хуудас 9.

Мөн БНХАУ-ын элчин сайдын яамаар дамжин санал тавьсан Банкок дахь олон улсын хурлын үеэр манай төлөөлөгчтэй уулзаж харилцаа холбоо тогтоох тухай санал тавьсан. 1989 оны 10 дугаар сард 3-нд БНСУ-ын сурвалжлагч манай Гадаад яамтай уулзах хүсэлт тавих үед бололцоогүй гэсэн хариу өгсөн байна. Дараа нь Гадаад явдлын яамны 3 дугаар хэлтсээс харилцаа тогтоох талаар 10 үндэслэл бүхий санал тавьсныг ГЯЯ-ны коллегийн хурал хийн БНСУ-тай дипломат харилцаа тогтоох нь зүйтэй гэж үзжээ. 1990 оны 2 дугаар сарын 14-ны өдөр МАХН-ын төв хороонд ГЯЯ-ны сайд дээрх саналыг хүргүүлсэн. Ингээд 1990 оны 3 дугаар сарын 22-ны өдөр МАХН-ын төв хороо БНСУ-тай харилцаа тогтоох чиглэл өгсний дагуу Улс төрийн товчоо тухайн үедээ маш нууц гэсэн зэрэглэлтэй дараах тогтоолыг батлав. Энэхүү тогтоолд: “МАХН-ын төв хорооны 5 дугаар бүгд хурлаас 1988 оны тус улсын гадаад бодлогыг өөрчлөн шинэчлэх зорилтын хүрээнд улс хоорондын харилцаанд үзэл суртлын болон бусад ялгааг урьтал болгохгүй, улс үндэстний эрх ашгийг дээдлэн үзэж байх талаар өгсөн заалтыг удирдлага болгон БНСУ-тай элчин сайдын хэмжээнд дипломат харилцаа тогтоох нь зүйтэй гэж үзсүгэй”<sup>6</sup> гэжээ.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтооход ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн, Японд суугаа элчин сайд Б.Дашцэрэн, Японд суугаа БНСУ-ын элчин сайд И.Үөн Гюн нар ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байдаг. Улмаар 1990 оны 3 дугаар сарын 26-ны өдөр БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн дарга П.Очирбат, нарийн бичгийн дарга Ч.Дашцэрэн нарын гарын үсэгтэй зарлигт “БНМАУ, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосугай” хэмээсэн байдаг.

Энэхүү түүхэн өдөрт ГЯЯ-ны 3 дугаар хэлтсийн дарга Ж.Чойнхор, мөн хэлтсийн ажилтан Р.Баасан, С.Доржпүрэв, Б.Лхагва, Ё.Отгонбаяр нар, БНСУ-ын талаас ГЯЯ-ны Зүүн Хойт Азийн 2 дугаар хэлтсийн дарга И.Сун Жин, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын тасгийн дарга И.Юн Хён нар оролцож дипломат харилцаа тогтоосныг зарлав.

Энэ үеэр хоёр орны эдийн засгийн харилцааг хөгжүүлж болох тодорхой хэдэн санал тавьсан. Тухайлбал, Коксжих нүүрсийг Намил, Самсунг зэрэг пүүсүүд сонирхож байна. Хэрэв БНМАУ-тай тохиролцон далайн боомт хүргэвэл зах зээлд борлуулах, зэс, молибедин, цайр, газрын ховор элемент зэргийг олборлох, баяжуулах, боловсруулах чиглэлээр хамтран ажиллах, үйлдвэрийн зориулалттай төрөл бүрийн цавуу, химийн мяндас зэргийг үйлдвэрлэх химийн үйлдвэр байгуулах, түүхий эд боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн гаргаж дэлхийн зах зээлд гаргах, хар төмөрлөгийн үйлдвэр, зэс хайлуулах үйлдвэрийг барихтай холбоотой бага оврын машин, тоног төхөөрөмж угсрах, үйлдвэрлэх, улмаар машины үйлдвэрийг хөгжүүлэх, электрон тоног төхөөрөмж угсрах үйлдвэр, үүнээс гадна био технологи, эрүүлийг хамгаалах, соёл, шинжлэх ухаан, технологийн (ШУТ-ийн) салбарт хамтран ажиллах, хүн сургах сонирхолтой байгаагаа илэрхийлж байв.

Мөн энэ үеэр Эдийн засгийн улсын хорооны 1 дүгээр орлогч дарга, БНМАУ-

<sup>6</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-01, Хуудас 20.

ын сайд Т.Намжим, ГЯЯ-ны орлогч сайд И Ги Жү, ЗХА-ын асуудал эрхэлсэн хэлтсийн дарга И Юн Хэн нарыг хүлээн авч уулзан хамтран ажиллах<sup>7</sup> хэд хэдэн асуудлаар ярьсан байна. Үүнд: Нэг удаагийн тариурын үйлдвэр барих, газрын тосны болон уул уурхайн салбарт хамтран ажиллах, ноолуур, тэмээний ноос, ангийн үс, бугын эвэр, архи, сүлжмэл, савхин эдлэл худалдан авах, зэс хайлуулах үйлдвэрийг Солонгосын тусламжтайгаар 90 онд багтааж ТЭЗҮ боловсруулах, цайр, кадмий, хагас дамжуулагч, хадан цагаан чулуу ашиглах үйлдвэр барихад хамтрах, БНМАУ дахь ашигт малтмалын нөөц, түүнийг ашиглах технологийн талаар хамтарсан судалгаа хийх, жуулчин, Иргэний агаарын тээвэрт хамтран ажиллах, ШУ, техникийн салбарт хамтрах, оюутан сургах, гаалийн татвараас чөлөөлөх, хамгийн бага хувь хүртэл хөнгөлөх, Худалдааны төлөөлөгчдийн газрыг нээх, сансрын холбоо бэхжүүлэхэд тусламж үзүүлэх, зам тээвэр, далайн боомт, төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэргийг ярилцаж тохиролцсон байна.

БНМАУ-ын Эдийн засаг гадаад харилцаа, хамтын ажиллагааны яамны орлогч сайд Ц.Молом, Өмнөд Солонгосын ГЯЯ-ны орлогч сайд И Ги Чу-г 3 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар ярилцсан зүйлс дотор хамтарсан үйлдвэр барих, байгалийн баялаг ашиглах, шинжлэх ухаан техникийн харилцаа холбоог хөгжүүлэх, зэс хайлуулж эцсийн бүтээгдэхүүн хийх, Хятадын боомтоор дамжуулан худалдаа хийх, эдийн засгийн нээлттэй бодлого баримтлах, Монголд хөрөнгө оруулан Европын зах зээлд гарах талаар судалж үзэх талаар ярилцсан.

Харин БНСУ-ын талаас: АХБ-ны гишүүн болоход дэмжих, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах, ШУТ-ийн салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулах, Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр байгуулах санал тавьсан. БНМАУ-ын ГЯЯ танилцуулах мэдээний 1990 оны 4 дүгээр сарын 1-ний өдийн дүгнэлтэд<sup>8</sup> БНСУ-тай ямар нэгэн болзолгүйгээр дипломат харилцаа шууд тогтоосон нь цаг үеэ олсон бөгөөд БНМАУ нь эдийн засгийн идэвхтэй бодлого явуулж, Азийн орнуудтай идэвхтэй харилцах чиг шугамаа тууштай хэрэгжүүлж байгааг дэлхийн олон нийтийн өмнө илтгэн харуулсан алхам болов.

БНМАУ ийм санаачилгыг Азийн социалист орнуудын дотроос түрүүлж гаргасныг БНСУ-ын тал зохих ёсоор үнэлж манай улстай харилцаагаа харьцангуй богино хугацаанд явуулж, улмаар БНМАУ-аас Япон улстай эдийн засгийн хамтын ажиллагаа хэрэгжүүлэхэд өрсөлдөгч хүчин болж чадах бөгөөд тийм ч эрмэлзэлтэй байгаа болов уу гэж үзэж болох байна.

4 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 2-ны өдрүүдэд БНСУ-ын Гадаад харилцаа, Үндэсний аюулгүй байдлын хүрээлэнгийн хүсэлтийн дагуу Шинжлэх ухааны академийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Л.Хайсандай БНСУ-д зочилсон нь нэгэн сонирхол татам баримт гэлтэй.

<sup>7</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-01, Хуудас 88.

<sup>8</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-01, Хуудас 143.

1991 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр манай талын тавьсан санал<sup>9</sup> ажил хэрэгч бөгөөд ихээхэн сонирхол татаж байгаа юм. Үүнд: Дарханд хуванцар эдлэл, тоормосны накладка, унадаг дугуйны үйлдвэр, суудлын автомашин угсрах цех, автомашины гэрэлтүүлэгч шил, автомашин, мотоцикл, унадаг дугуйны резин дугуй, шалны хулдаас, цахилгаан хөдөлгүүр үйлдвэрлэх цех зэрэг жижиг үйлдвэр БНСУ-тай хамтарч барих санал нотоор тавьсан боловч хариу өгөөгүй байдаг.

Мөн оны 3 сарын 27-30-ны өдрүүдэд Ц.Гомбосүрэн сайд БНСУ-н Гадаад хэргийн сайд Ли Сан Үгийн урилгаар БНСУ-д албан ёсны айлчлал хийв. Энэ үеэр хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах тухай хэлэлцээр, Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтрах тухай хэлэлцээр, Соёлын талаар хамтрах хэлэлцээр, Худалдааны хэлэлцээрт тус тус гарын үсэг зурсан нь түүхэнд тэмдэглүүштэй чухал хамтын ажиллагаануудын эхлэл болсон юм.

1991 оны 9 дүгээр сарын 2-7-ны өдрүүдэд Засгийн газар хоорондын иргэний агаарын тээврийн хэлэлцээрийг үзэглэсэн нь үр өгөөжөө өгөн 2018 оны байдлаар 7 хоног бүр МИАТ 5 удаа, КАЛ 5 удаа, Айр Бусан 2 удаа иргэний зорчигч тээврийг тасралтгүй хийсээр байна.

Мөн оны 11 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд Дэү компанийн хүмүүс сүлжмэлийн 1, 2 дугаар үйлдвэртэй танилцаж 280 гаруй машин, тоног төхөөрөмжийн жагсаалт авч, үнийн талаар эргэж мэдээлэхээр болсон төдийгүй шилний үйлдвэрийн талаар 8 сая ам.долларын төсөл авч ирсэн. Энэ нь 1.5-2.0 сая м2 шил үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барих нь ашигтай гэж үзэж байгаагаа мэдэгдсэн. Энэхүү үйлдвэрийг барих хүсэл одоо ч гэсэн Монголын ард түмэн дунд яригдаж бичигдсээр байна. БНСУ-ын талын хүмүүс усны хомсдолоос болж энэхүү төсөл хэрэгжээгүй тухай их бичдэг.

1993 оны 7 дугаар сарын 18-нд Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах тухай Монгол Улсын засгийн газар, БНСУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээрт УГЕГ-ын дарга Г.Сэсээр, БНСУ-ын гаалийн газрын дарга Ким Гён Тэ нар Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан<sup>10</sup> нь хоёр улсын худалдааны харилцааны чухал алхам болов.

Архивын материалуудаас үзэхэд тухайн үеийн БНМАУ-ын төр засгийн эрх баригч гол хүчин болох МАХН-ын Улс төрийн Товчооноос БНСУ-тай дипломат харилцаа тогтоох шаардлагатайг дараах 7-8 үндэслэлийн гарган тайлбарласан байдаг. Үүнд: 1. БНСУ-ыг дэлхийн 140 шахам улс орон хүлээн зөвшөөрч тус орон дэлхийн улс төрийн, эдийн засгийн бодлогод бодит хүчин болон хувирчээ. 2. Худалдаа эдийн засгийн салбарт хамтран ажиллах нь манай талд эдийн засгийн талаар үзэмж ашигтай. 3. Өмнөд Солонгосыг дэмжигч нөлөөтэй улс гүрний дунд манай улсын нэр хүндийг өргөж, гадаад бодлогын үйл ажиллагааны салбарт хийж буй шинэчлэлийг харуулж, улс төрийн ач хологдолтой алхам болно. 4. Япон улс

<sup>9</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-03, Хуудас 01.

<sup>10</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-13, Хуудас 01.

БНМАУ-аас Өрнөдийн орнуудтай явуулах эдийн засгийн хамтын ажиллагааг монопольлох өөрийн нөхцөлийг тулган хүлээлгэх хадлага гаргаж болзошгүй японтой өрсөлдүүлэн гаргаж ирэх нь манай талд ашигтай болно. 5. Ази Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцад манай улс хамрагдан ороход нааштай нөлөө үзүүлнэ. 6. Ази Номхон далайн бүс нутгийн хойд хэсгийн орнуудын хооронд байнга үйлчлэх яриа хэлэлцээний механизм буй болгох тухай БНМАУ-ын дэвшүүлсэн шинэ санаачилгын нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл мөн гэж үзэх хэрэгтэй юм. 7. Өмнөд Солонгос “Дорнодын бодлого”-оо тунхаглан Европын социалист орнуудад өрнөж буй үйл явцын хүрээнд тэдгээр оронтой холбоогоо өргөжүүлж байгааг анхааралдаа авч БНМАУ-тай аливаа хэлбэрээр холбоо тогтоох сонирхол нь буураагүй байгаа өнөөгийн нөхцөлд холбоо тогтоох нь зүйтэй гэж үзнэ” гэсэн буй.<sup>11</sup>

Харин энэ үед БНАСАУ-ын элчин сайд Ким Тайг Рюү, ГЯЯ-ны 1 дүгээр орлогч сайд Д.Ёндонтой уулзан Монгол Улсыг БНСУ-тай харилцаа тогтоохыг эрс эсэргүүцэж буйгаа удаа дараа мэдэгдсэн. Дараа нь гарах сөрөг үр дагаврыг бодсон эсэх талаар хатуу ширүүн үг хэллэгтэй, дайсны талд орлоо хэмээн зэмлэсэн утгатай байв. Гэвч энэ бол Монголын ард түмний эрх ашигт нийцэж буй тул элдэв үзэл суртал, улс төрийн агуулгыг дараагийн дугаарт тавин Монгол Улс нь тусгаар улсын хувьд бие даан шийдвэр гаргах эрхтэй бөгөөд БНСУ-тай дипломат харилцаа тогтоох явдал нь манай хоёр орны харилцаанд нөлөөлөх ёсгүй бөгөөд БНАСАУ-тай харилцаагаа бүхий л аргаар хөгжүүлэх чиг шугамаа цаашид ч баримтлах талаар сайд Д.Ёндон хариу хэлсэн байна.

Энэ нь Монгол Улсын хувьд бие даан гаднын улстай харилцаа тогтоох шийдвэр гаргасан чухал мөч юм. Энэ үеэс хойш өнөөдрийг хүртэл Стратегийн түншлэлийн харилцаанд хүрэх босгон дээр тулж ирээд байна. Улс төрийн харилцааг модтой зүйрлэвэл гол, мөчиртэй дүйцэж болох юм. Харин энэхүү харилцаа нь уламжлалаа хадгалсан шинэчлэлийг баримтлахгүй бол улс төрийн шинэ хүчин гарах бүрд урдхаа үгүйсгэн шинэ гэрээ, хэлэлцээ явуулж байгаа нь алдаатай бодлого болно.

### **ЗХА дахь эдийн засгийн харилцаа**

ЗХА-ийн эдийн засгийн эргэлт явагдаж эхэлснээр хөгжил ирэх тул Монгол Улс, БНСУ-ын хувьд Хятад, Умард Солонгостой хамтын ажиллагааны бодит судалгаа хийгдсэн байх ёстой. Олон улсын эдийн засгийн хоригоос шалтгаалан Умард Солонгостой одоохондоо эдийн засгийн харилцаа хөгжүүлэх боломжгүй боловч Монгол, Солонгос, Хятад гэсэн гуравласан эдийн засгийн харилцааны бодит судалгаа эхлүүлэх зайлшгүй шаардлага байна. Манай хоёр улс Хятадын нутгаар дамжин тээвэр хийхээс өөр аргагүй. Тиймээс хоёр талын харилцаа гэхээсээ илүү гурван талт, бүр цаашилбал Япон, АНУ, ОХУ, БНАСАУ зэрэг 7 талт хамтын ажиллагааны загварыг боловсруулах сорилт тулгараад байна. АНУ нь дэлхийн

<sup>11</sup> Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, ХД-112, ДД-01, ХНД-01, Хуудас-01.



дэг журам тогтоох сонирхлоо алдаж байгаатай холбоотойгоор ойрын 2-3 жилд олон улсын худалдааны бүтэц нуран унах, улмаар Солонгосын экспорт хүнд байдалд орох эрсдэлтэй байна. Тиймээс ч Солонгос нь Япон улстай худалдааны харилцаагаа сайжруулах оролдлого хийж эхэлжээ. Геополитикийн хувьд Японд Солонгосын хэрэг байхгүй боловч Солонгост Японтой харилцах хэрэгцээ байгаа учраас Солонгос нь Японыг дагахаас аргагүй байдалд хүрнэ. Нэгэнт АНУ нь ЗХА-д нөлөөгөө алдаж, Хятадын эдийн засаг цаашид саарах аваас энэхүү бүс нутагт Японы нөлөө их болох тул бүс нутгийн улсууд цаашдын стратегиа дахин боловсруулах шаардлагатай хэмээх хандлага ч байна. ЗХА дахь худалдааны дайн нь өөрийн улсын зах зээлийг хамгаалах, хилийн маргаан, худалдааны бодлого, өнгөрсөн түүхэн хугацааны зөрчилдөөн зэрэг олон асуудал давхцан улам бүр газар аваад байна. Хятад нь империалист шударга бус худалдааны бодлого, Өмнөд Солонгос, Японы экспортыг дэмжих, импортыг хаах бодлого, Умард Солонгос нь өөрийгөө хангах эдийн засгийн хүрээнд хэрэгтэй мөнгө олох худалдааны бодлого зэргийг баримталж буй тул ЗХА-д худалдааны дайн улам ширүүсэх төлөвтэй талаар судлаачдын байр суурь ч их бий.

Монгол, Умард Солонгос, Орос, Хятад нь хоорондоо төмөр замаар холбогдсоноор АНУ, Япон, Өмнөд Солонгосын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, улмаар аялал жуулчлал, эрчим хүч, ашигт малтмалыг хамтарч ашиглах зэрэг эдийн засгийн олон талт хамтын ажиллагаа эхлэх үндэстэй.

Хэдийгээр Умард Солонгосын цөмийн зэвсэг, Өмнөд Солонгос-Японы гадаад харилцаа, АНУ-Хятадын худалдааны дайн зэрэг шийдэх хэрэгтэй олон асуудал байгаа боловч өөрчлөх боломжтой юм. Энэхүү өөрчлөлтөд бэлдэх, ТЭЗҮ боловсруулах гэх мэт бүс нутгийн судалгаануудыг хийж дуусгах шаардлагатай.

Олон улсын эдийн засгийн хоригт ороогүй ганц салбар нь аялал жуулчлал, төмөр замын салбар юм. Монголын зүүн 3-н аймаг, Хятадын зүүн хойд 3-н муж, Өвөр Монголын Хянганы аймаг, Оросын Алс Дорнод, Умард Солонгос, Өмнөд Солонгос зэрэг улсууд ЗХА-ийн аялал жуулчлалд өөр өөрийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Хятадын 13 дугаар 5 жилийн төлөвлөгөөнд аялал жуулчлалын 20 гаруй бүс нутгийг онцолсны дотор зүүн хойд 3-н мужид багтдаг Чанбайшин, Хянганы нуруу, Хар мөрөн мужийг 5А зэрэглэлд багтаасан.<sup>12</sup>

ОХУ-ын улсын хувьд Приморын хязгаар дах Камчаткийн хойг, Горный воздух, “Ирвэсийн нутаг” үндэсний парк, Тобизина мыс гэсэн 4-н газрыг аялал жуулчлалын бүс болгон зарлаж төлөвлөгөөг танилцуулсан.

Умард Солонгос нь 1980 онд эдийн засгийн өсөлтийг дэмжин аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх болж 1986 онд аялал хариуцсан хэлтсийг Улсын аялал жуулчлалын агентлаг болгон өргөжүүлсэн. Улмаар 1987 онд Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, 1993 онд Ази Номхон далайн аялал жуулчлалын холбоонд гишүүнээр элсэж, 1991 онд Расон худалдаа, эдийн засгийн бүс байгуулан

<sup>12</sup> [http://www.kiep.go.kr/m/sub/view.do?bbsId=search\\_report&nttId=203559](http://www.kiep.go.kr/m/sub/view.do?bbsId=search_report&nttId=203559)

Гөмган уул, Үоньсан бүс, Үоньсан Галма далайн эрэг зэргийг багтаасан аж.

2019 оны 9 дүгээр сард “ЗХА-ын төмөр замын хамтын нийгэмлэг”-ээс ЗХА-ийн төмөр замын нэгдсэн сүлжээний зургийг гаргасны дотор Дорнод аймгаар дайрч өнгөрөх төмөр замын босоо шугам багтаагүй. Тус нийгэмлэг нь зорчигч тээвэр, ачаа тээвэр, техникийн стандарт зэргийг иж бүрэн хариуцаж ажилладаг байгууллага тул дээрх зураглалд Монголын төмөр замын төлөвлөгөөг уялдуулах талаар цаашид идэвхтэй ажиллах хэрэгтэй. Ялангуяа хил дамнасан төмөр замын аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр түлхүү ажиллаж байгааг анзааран оролцоогоо нэмэгдүүлэх шаардлагатай. Ирээдүйд Умард Солонгостой, цаашлаад Өмнөд Солонгостой төмөр замаар холбогдох бодлого барих нь зүйтэй.

Монгол улс, БНСУ-ын засгийн газар хоорондын хамтарсан хорооны IV хуралдаан 2019 оны 6 дугаар сард Сөүл хотноо болж олон талт, бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний сүлжээ, Зүүн Азийн Төмөр замын хамтын нийгэмлэг байгуулах зэрэг бүс нутгийн санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллахаар тохирсон.<sup>13</sup> Дээрх санаачилга нь БНСУ-ын Шинэ умардын бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр бэлтгэж буй олон улсын хамтын ажиллагаа юм.

БНСУ-ын ерөнхийлөгч Мүн Жай Ин Зүүн азийн төмөр замын нэгдсэн нийгэмлэгийн ажлыг хэрэгжүүлэхээр 2018 оны 9 дүгээр сард НҮБ, 10 дугаар сард АСЕМ, 11 дүгээр сард их 20, 2019 оны 6 дугаар сард Ослогийн форум зэрэг дээр илтгэл тавьж, олон улсад зарласан.<sup>14</sup> Түүнчлэн БНСУ-ын хөгжлийн хүрээлэн, Төмөр замын байгууламжийн цогцолбор, Зам тээврийн яам гэсэн 3-н байгууллага энэ талаар идэвхтэй ажиллаж, ЗХА-ийн улсуудыг хамарсан эрдэм шинжилгээний хурал, форум, олон улсын семинар зэргийг зохион байгуулсаар байна. Хэрэв төмөр замын сүлжээ байгуулагдан ашиглалтад орвол ЗХА-ийн хөгжлийн гол судас болох юм. 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Сөүл хотод болсон төмөр замын тээврийн хөгжлийн уулзалтаар ачаа тээврийн одоогийн байгаа хамгийн тохиромжтой 4-н коридорыг нэрлэсэн. Энэхүү коридороор дамжуулан төмөр зам, эдийн засгийн чөлөөт бүс, бараа эргэлт, аялал жуулчлал, уул уурхай зэрэг 30 гаруй эдийн засгийн хамтын ажиллагааны санал тусгагджээ. 2020 онд оролцох улсуудын хоёр болон олон талт зөвлөлдөх бүтцийг байгуулан 2022 онд жишээ болохуйц тээврийн дэд бүтцийн бодит үр дүнг гаргаж, 2023 оны сүүл гэхэд Олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЗХА-ийн төмөр замын хамтын нийгэмлэгийн замын зураглалыг байгуулахаар ажиллаж байна. Цаашид гаргасан саналын дагуу санхүү босгох, ТЭЗҮ боловсруулах зэрэг ажлыг хийх төлөвлөгөөтэй ажээ.

БНХАУ нь 2005 онд сэргээгдэх эрчим хүчний хууль баталснаар 2018 онд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь нь 37.4 хувьд хүрсэн. Үүнээс усны эрчим хүч 18.5%(350GW), салхины эрчим хүч 9.7%(180GW), нарны эрчим хүч 9.2%(180GW),

<sup>13</sup> <http://www.mfa.gov.mn/?p=51863>

<sup>14</sup> <http://www.sisarecord.com/news/articleView.html?idxno=362>

био эрчим хүч 0.9%(17.8GW)-ийг эзэлж байна. Хятадын цаашдын эрчим хүчний нэмэгдэх нийлүүлэлт нь Солонгосыг хангаснаар Монгол Улсын эрчим хүчний гадаад зах зээлийн том өрсөлдөгч болох өндөр магадлалтай юм.<sup>15</sup>

Японы эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн судлаач Такаши Озуки Солонгос, Японы хоорондох эрчим хүчний сүлжээ байгуулан Японы Гюшү хотод нарны цахилгаан станц байгуулж, Солонгос руу нийлүүлэх, Солонгос илүүдэл эрчим хүчээ Японд нийлүүлэх нь харилцан ашигтай байх, эдийн засгийн болон эдийн засгийн бус үр ашгийн тооцоог танилцуулсан аж.

Харин ОХУ-ын талаас Солонгостой эрчим хүчний сүлжээ байгуулах, өргөжүүлэх, илүүдэл эрчим хүчний эрэлт нийлүүлэлтийн тооцоог даруй хийх шаардлагатай байгаа талаар дурджээ. Түүнчлэн эрчим хүчний өсөлттэй холбоотой ОХУ, ЗХА-ийн улс хооронд шинэ эрчим хүчний хамтын ажиллагаа, загварын өөрчлөлт сэдвийн хүрээнд илтгэл тавьж, ОХУ-ын сэргээгдэх эрчим хүчний өнөөгийн түвшин болох 0.5%-ийг 2035 он гэхэд 2.5-4.5% болгох төлөвлөгөөг танилцуулсан. ОХУ-ын талаас алс дорнодын усны, нарны, салхины арвин их нөөц буйг тэмдэглээд, мэдээж газрын тос, байгалийн зэрэг олон эх үүсвэрээр ЗХА-ийг хямд эрчим хүчээр хангах боломжтой хэмээсэн байна. Хятадтай хамтран 50GW-ын салхин цахилгаан станцын ТЭЗҮ хийгдэж дууссан бөгөөд энэхүү цахилгаан станц ашиглалтад оруулж, ЗХА-ийн эрчим хүчний сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлэх талаар ажиллаж байна гэжээ.

Өмнөд Солонгосын талаас сэргээгдэх эрчим хүчний өнөөгийн түвшин 7.6%-ийг 2040 он гэхэд 30-35% хүргэх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд дотоодын аж ахуй нэгжүүдийг гадаадад сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулахад нь засгийн газраас дэмжих, бүс нутгийн улсууд хоорондоо мэдээлэл солилцох, хамтарч шинэ технологи хөгжүүлэх, хууль эрх зүйг боловсронгуй болгох зэрэг олон саналыг дэвшүүлжээ.

Өнөөдөр улс орнуудын эрчим хүчний давтамж, хүчдэлийн ялгаа зэрэг олон зөрүүтэй тоо байгаа боловч тогтмол гүйдлийн өндөр хүчдэл(HVDC)-ийг ашиглавал хүндрэл үүсэхгүй талаар мэргэжилтнүүд хэлдэг. Энэ талаар дэлхийн 80 гаруй улс хоорондоо эрчим хүчний сүлжээгээр холбогдсон туршлага ч бий. Хятадын Глобал эрчим хүчний холболт, хөгжил, хамтын ажиллагааны байгууллага, Солонгосын цахилгаан шугам сүлжээ угсралтын компанийн хооронд хоёр улсын цахилгаан сүлжээний хамтарсан судалгаа ид дундаа явж байна. Япон, Солонгосын цахилгаан шугам сүлжээ болон далайн орчны судалгаа хийгдэж дууссан талаар Японы Софт банк компанийн зүгээс мэдэгдсэн байдаг. Түүнчлэн ОХУ, Солонгосын хооронд цахилгаан эрчим хүчний сүлжээ байгуулах ТЭЗҮ 2021 онд дуусахаар ажиллаж байна.

Энэ бүгдээс үзэхэд ойрын хугацаанд сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийн хувьд ЗХА-д манай өрсөлдөгч нь ОХУ юм. Монгол Улсыг бодвол дотоодын эрчим

<sup>15</sup> <http://www.epj.co.kr/news/articleView.html?idxno=23384>

хүчний сүлжээ нэлээд хийгдсэн, усан цахилгаан станц сайн хөгжсөн газар юм. Харин Хятадын эрчим хүчний эрэлт нь нийлүүлэлтээсээ ямагт их байх төлөвтэй учир манай хэрэглэгч болох магадлал өндөр юм. Солонгос, Япон улсын хувьд дотоод нөөцөө ашиглан эрчим хүчний нийлүүлэлтээ хангахаар ажиллаж байгаа боловч нөөц нь хязгаарлагдмал тул одоохондоо гадагшаа чиглэсэн бодлого баримталж байна. Ялангуяа Монгол Улсын сэргээгдэх эрчим хүч, цахилгаан шугам сүлжээний төслүүдэд оролцох сонирхол их бий. Манай орны хувьд сэргээгдэх эрчим хүчний хууль, санхүүгийн тогтолцоо, хөрөнгө оруулалтын таатай орчин, татварын хөнгөлөлтийн систем зэрэг олон асуудлыг маш хурдан шийдэхгүй бол өрсөлдөгч нартаа зах зээлээ алдаад зогсохгүй, Хятад, Солонгос, Япон зэрэг улсууд нь дотооддоо эрчим хүчээ бүрэн хангах шинэ технологи нэвтрүүлэхийг үгүйсгэхгүй. Хоёр улсын эдийн засгийн харилцааг модтой зүйрлэвэл үр жимстэй дүйцэж болох юм.

## ДҮГНЭЛТ

Манай хоёр улсын харилцаа цаашид байнгын хамтын ажиллагаатай, харилцааг хөгжүүлэх тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай, ард түмэн, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг байгуулах, төлөвлөх, цар хүрээг тогтоох, үнэлэх дүгнэх нэгдсэн философитой болох нь зүйтэй санагдаж байна. Түүнчлэн хоёр улсын хооронд соёлын харилцаа багагүй байгаа боловч төлөвлөсөн, хамтарсан бодлого, онол байхгүйн улмаас цаашид хэрхэн хөгжих нь тодорхойгүй, цаг үеийн урсгалаар явж байгаа төдийхөн байна. Цаашид соёлын дипломат ажиллагаа, соёлын харилцааны талаарх нэгдсэн ойлголт байр суурийг онолын үндэстэй хөгжүүлэх хэрэгтэй болов уу. Улс төрийн харилцааны хувьд анх дипломат харилцаа тогтоож байхад хэлж ярьж байсан зүйлсээ одоо ч давтан хэлэлцсээр иржээ. Хэдийгээр улс төрийн харилцаа сайн байгаа мэт харагдаж байгаа хэдий ч амлалтуудаа алхам алхмаар хэрэгжүүлж эхлэх нь чухал юм. Ингэж гэмээ нь эдийн засгийн харилцаа гүнзгийрч хоёр улс харилцан ашигтай байж, үр шим хүртэх үндэстэй болно. Өөрөөр хэлбэл байнгын хамтын ажиллагаа, соёлын харилцаа гэдэг нь үнэт зүйл дээр ихэвчлэн тогтдог учир итгэлцэл бий болгох суурь болно. Дараа нь хоёр орны эрх ашгийг илэрхийлэх улс төр, эдийн засгийн харилцаа хөгжихөд хялбар болох юм. Зүйрлэвэл соёлын хөрсөн дээр итгэлийн үр суулгаж, байнгын хамтын ажиллагаагаар усалснаар улс төрийн харилцааны том мод ургаж, эдийн засгийн байнгын үр жимсээ өгөх хоёр улсын цогц харилцаа үүсэх юм.

## НОМ ЗҮЙ

1. Зүүн Хойт Ази судлал сэтгүүл, 1999, №1.
2. Шим И Соб, Г.Мөнхнасан, Зүүн хойд азийн эрин үе ба Монголын эдийн засаг, 2010 он.
3. Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив.
4. “Монгол, Солонгосын харилцааны түүх ба ЗХА-ийн хамтын ажиллагаа”, хурлын эмхэтгэл, 2019.
5. Фрэнсис Фукуяма, “Итгэлцэл-2”, NERKO.
6. Монгол Улсын Гадаад харилцааны яам-<http://www.mfa.gov.mn/>
7. Солонгосын олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэн-<http://www.kiep.go.kr/>
8. “Солонгосын эдийн засаг” портал сайт-<https://www.hankyung.com/>
9. БНСУ-ын портал сайт-<http://www.sisarecord.com/>
10. БНСУ-ын цахилгаан эрчим хүчний сэтгүүл-<http://www.epj.co.kr/>

